

ЗҮҮН ХОЙТ АЗИ: ХӨГЖЛИЙН ХАНДЛАГА

*Ц.Баатар**

*Б.Сэржав***

Эдүгээ дэлхийн эдийн засгийн глобалчлал, интеграцчилалын үйл явц эрч хүчээ авч, улс орнуудын хөгжлийн стратеги энэ үйл явцтай улам бүр нягт уялдах боллоо. Саяхан Европын Холбоо 10 шинэ гишүүнээр эгнээгээ өргөжүүлсэн нь үүний нэг тодорхой нотолгоо юм. Ингэснээр Европын Холбооны гишүүн орон нийтдээ 25 болж, хүн ам нь 370 саяас 470 сая болж нэмэгдэв. Энэ нь АНУ болон ОХУ-ын хүн амын тоог нийлүүлснээс илүү гарлаа гэсэн үг. Европын Холбоо ийнхүү өргөжин тэлснээр дэлхийн хамгийн том нэгдмэл зах зээл бий болох таатай боломж бүрдлээ. Энэ нэгдмэл зах зээлийг бүрдүүлж буй 25 улсад дэлхийн худалдааны дөрөвний нэг, буурай хөгжилтэй орнуудад олгодог тусламжийн тэн хагасаас илүү нь ногдох аж. Шинээр гишүүнээр элссэн орнууд өөрсдийн өсөн дэвжих хөрсийг тэндээс олж харсан учраас холбооны зүгээс тавьсан нэлээд чанга нөхцөл болзол /гол нь эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлт/ нэг бүрийг хүлээн авч биелүүлснээр уг холбоонд элсэж чадлаа. Шинэ гишүүн орнуудын өмнө Европын Холбооны эрхэм зорилго болох эрх чөлөө, ардчилал, хөгжил дэвшлийн үзэл санааг хуваалцах түүхэн боломж ийнхүү нээгдлээ. Дэлхийн хөгжлийн чиг хандлагатай уялдан Европын Холбоо цаашид ч эгнээгээ тэлэн өргөтгөж ойрын ирээдүйд Европын орнууд нэгдсэн нэг засаглалтай болох магадлал улам бүр өндөрсөв.

Энэхүү түүхэн үйл явдал нь бидний оршин буй Зүүн хойт Азийн бүс нутгийн интеграцын үйл явцыг улам бүр эрчимжүүлэхэд шинэ хүчин түлхэц өгч, хүчтэй нөлөө үзүүлэх нь дамжиггүй.

Өнгөрсөн хугацаанд Зүүн хойт Азийн бүс нутгийн интеграцын үйл явцыг урагшлуулахад АНУ-ын Хавайн Гонолулу дахь Дорно-Өрнө төв болон бүс нутгийн орнуудын санаачлагаар 1992 онд байгуулагдсан “Зүүн хойт Азийн Эдийн Засгийн Форум” (ЗХА ЭЗФ) байгууллага чухал үүрэг гүйцэтгэж ирлээ. Форум бүс нутгийн орнуудын судалгааны болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, санал солилцож, практик дүгнэлт хийхэд голлон анхаарч, үйл ажиллагааныхаа гол

*Ц.Баатар - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

**Б.Сэржав - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

хэлбэр болох олон улсын бага хурлыг жил тутам уламжлал болгон зохион байгуулж байна.

Форумын ээлжит хуралдаан сүүлийн үед гол төлөв Японы Ниигата дахь Зүүн хойт Азийн эдийн засгийн хүрээлэн дээр төвлөрөн санхүүжиж ирэв. Энэ оны ээлжит хуралдаан хоёрдугаар сарын эхээр мөн тэнд болж өнгөрлөө. Хуралдаанд уламжлал ёсоор бүс нутгийн орнуудын эрдэмтэн судлаачид, улс төр, бизнесийн төлөөлөл оролцож, бүс нутгийн хөгжлийн өнөөгийн байдал, хэтийн төлөв, тулгарч буй асуудлуудыг дэлхийн хөгжлийн өнөөгийн чиг хандлагатай уялдуулан авч хэлэлцжээ.

Хуралдаанаас глобалчлал, интеграцын үйл явцын өнөөгийн ерөнхий чиг хандлага бүс нутгийн эдийн засаг интеграцчлагдах зайлшгүй нөхцлийг бий болгож байгаа хэдий ч Зүүн хойт Азийн бүс нутгийн хувьд энэ үйл явц хэрэгжихэд бодитой саад бэрхшээл оршсон хэвээр байгаа төдийгүй тодорхой цаг хугацаа шаардана гэсэн дүгнэлтэд хүрсэн аж.

Бүс нутгийн орон тус бүрийн эдийн засгийн хөгжлийн өнөөгийн байдлыг зэрэгцүүлэн үзэж, үнэлэлт дүгнэлт өгөх, бүс нутгийн хүчин зүйлийг Монгол Улсын хөгжлийн хэтийн төлөвтэй уялдуулан цогц байдлаар авч үзэх бодит шаардлагын үүднээс бид Зүүн Хойт Азийн орнуудын хөгжлийн хандлагын талаар хийж буй цуврал судалгааныхаа энэ хэсэгт бүс нутгийн орнуудын 2003 оны хөгжлийн гол үзүүлэлтүүдэд тулгуурлан зарим нэг үнэлэлт дүгнэлт өгөх оролдлого хийлээ.

Өнгөрсөн онд SARS болон бусад хүчин зүйл нөлөөлсөн хэдий ч ЗХА-ийн орнуудын ДНБ нийлбэр дүнгээрээ судлаач, шинжээчдийн таамаглаж байснаас илүү түвшинд хүрч 6.5 хувиар өссөн байна. Түүнчлэн Японы эдийн засгийн өсөлт зогсонги байдалд орж ойрын хэдэн жил дараалан хасах үзүүлэлттэй гарч байснаа 2002 оны сүүлчээс аажим өсч, 2003 онд 2.3 % -иар өссөн нь бүс нутгийн төдийгүй дэлхий дахины эдийн засагт гарсан чухал үйл явдал боллоо. Түүнчлэн Хойд Солонгос дэлхий нийтийн хөгжлийн өнөөгийн жам ёсны хандлагыг арга буюу хүлээн зөвшөөрч улс орныхоо эдийн засгийг зах зээлийн чиг баримжаатай хөгжүүлэх шийдвэр гаргаж, эдийн засгаа либералчлах чиглэлээр зарим нэг алхам хийж эхэлсэн нь өнгөрсөн оны онцлох үйл явдлын нэг байлаа. Хятад улсад гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ анх удаа 60 тэрбум ам.долларт хүрснээр бүс нутагтаа төдийгүй дэлхийд энэ үзүүлэлтээрээ тэргүүлж эхэллээ. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын энэхүү огцом өсөлт нь ДНБ-ний өсөлтөд ч эерэг нөлөө

үзүүлжээ. Монголоос бусад орны гадаад худалдааны баланс ашигтай байв. Өмнөд Солонгост улс төр, санхүүгийн дуулиант хэрэг гарч, эдийн засаг нь 2002 оны 6.1%-ийн өсөлтөөс буурч 3.1%-ийн өсөлттэй байв. Бүс нутгийн орнуудын эдийн засаг ийнхүү нийтдээ өсөлттэй гарсан нь дотоодын эрэлт өсч, экспортын хэмжээ болон гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдсэнтэй холбоотой гэж шинжээчид үзэж байна. Бүс нутгийн орнуудын эдийн засгийн өсөлтийг Хятад улс 9.1%-ийн үзүүлэлтээр аанайл тэргүүлж явна. Хятадын эдийн засгийн эрчимтэй өсөлт бүс нутгийн орнуудын эдийн засагт ч нааштай нөлөө үзүүлж буй аж. Одоо бид ЗХА-ийн бүс нутгийн орнуудын эдийн засгийн өсөлт хөгжлийн байдлыг Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Олон улсын валютын сан, The Economist, Asian Survey болон Японы Ниигатагийн ЗХА-ийн эдийн засгийн хүрээлэн, бусад судалгаа, статистикийн материалуудыг ашиглаж орон тус бүрээр нь арай дэлгэрэнгүй авч үзье.

Япон

Япон улсын хувьд өнгөрсөн онд ДНБ-ий өсөлт 2.3% байсан хэдий ч амаргүй жилүүдийн нэг болж өнгөрлөө. Бүс нутгийн орнуудад гарсан SARS, Иракийн дайн, дотоодын банк санхүүгийн хүндрэл зэрэг нь эдийн засгийн өсөлтийг доош чангаасан хүчин зүйлс байлаа. Гэсэн хэдий ч 2003 оны сүүлийн 3 сар дараалан эдийн засаг 7 хувийн өсөлттэй байсан нь жилийн нийт өсөлтөд ийнхүү эерэг нөлөө үзүүлэв. Ажиглагчид, шинжээчид энэ үйл явцыг Азид цоо шинэ хүчин эрчээ авч эхэлсний шинж тэмдэг хэмээн өөдрөгөөр үзэж талархалтайгаар угтан авлаа. Түүгээрч барахгүй Азийн энэ шинэ хүчин бол Хятад биш агаад харин ч Азийн мартагдах дөхсөн үлэмж биетэн Японы эдийн засаг байр сууриа эзэлж эхэлсний дохио гэж үзэж байна. Өнгөрсөн онд тус улсын экспортын хэмжээ сүүлийн жилүүдийн дунджаас 17.9 хувиар огцом өсчээ. Чанаргүй зээлийг 13%-иар бууруулсан аж. Түүнчлэн мөнгөний бодлого зохицуулагчид иений ханшийг доод түвшинд барьж байхын тулд 187 тэрбум ам. доллартай тэнцэх хэмжээний иен гадагш зарснаар валютынхаа ханшийг тогтворжуулах алхам хийлээ. Ингэснээр оны эцэст 107 иен нэг ам. доллартай тэнцэх боллоо. Японы эдийн засагт дефляцын сөрөг үйлчлэл явагдаж байгаа ч ихэнхи томоохон корпорацуудын борлуулалтын хэмжээ эрс нэмэгдэж балансын ашиг өссөөр байгаа аж. Автомашины үйлдвэрлэл анхаарал татахуйц өсчээ. Эдгээрийн дотор “Toyota” давамгайлж араас нь “Honda”, “Nissan”, “Mitsubishi” дагалдаж явна. Түүнчлэн компани, фирмүүд дотоодын

болон гадаадын зах зээлийн эрэлт хэрэгцээний өсөлтийг харгалзан үйлдвэрлэлийнхээ багтаамжийг нэмэгдүүлэхэд ихээхэн анхаарах боллоо. Эдгээр корпорацуудын амжилтын үндэс нь Америк болон Азийн зах зээл дээрх бүтцийн өөрчлөлтийн эерэг нөлөө байлаа. Тоёота 3 жил дараалан нийт ашгийн хэмжээгээрээ үндэсний рекордыг тогтоолоо. 2003 онд дотоод гадаадын зах зээлд нийтдээ 6.24 сая автомашин борлуулснаар ашиг нь өмнөх оныхоос даруй 27%-иар өссөн байна. Энэ корпораци нийт зардлынхаа хэмжээг 300 тэрбум иенээр хорогдуулж чадсан аж. Хонда-гийн автомашины гадаад борлуулалт 14% өсч рекорд үзүүлэлтэд хүрчээ. Ниссан борлуулалтын хэмжээгээр гуравдугаарт, нийт ашгийн хэмжээгээр 2-рт орох болов. Тус улсын бусад корпорацуудын үйл ажиллагаа ч гэсэн өнгөрсөн оны хувьд ихэнхи нь эерэг үзүүлэлтэй гарлаа. Тухайлбал, үүрэн телефоны зуутын сүлжээний NTT корпорацийн үндсэн үзүүлэлт сайжирч балансын ашиг нь 5.6 хувь өсч, 1567 тэрбум иенд хүрсэн нь рекорд үзүүлэлт аж. Интернет хангамжийн “I-Mode” өөрийн үйлчилгээг өргөтгөж, “FOMA” телефон холбооны хөгжлийн гуравдах үед шилжин орж байна. Гоо сайханы барааны “Шисэйд” фирмийн жилийн борлуулалт 5.3 хувь өсч, 621,2 тэрбум иенд хүрчээ. Балансын ашиг нь 48,9 тэрбум, цэвэр ашиг нь 24,4 тэрбум иен болжээ. Түүнчлэн хөрөнгө оруулалтын хэмжээ нь 2003 оны сүүлийн 3 сард 22 %-иар нэмэгджээ. Дэлхийд нэр хүндтэй 20 корпорацийн 2003 оны рейтингээр 3-рт Тоёота, 10-рт Сони, 15-рт Хонда эрэмблэгджээ. Японы эдийн засгийн сүүлийн үеийн сэргэлт нь зөв үндэс суурин дээр суурилсан, цаашид ч тогтвортой өсөх магадлалтай гэж судлаачид үзэж байна.

Дэлхийн банкнаас Японы эдийн засгийн гол гол үзүүлэлтүүд болох ДНБ, инфляц, ажилгүйдэл ямар байгаа болон цаашид ямар байх талаар дорх таамаглалыг дэвшүүлжээ. Өнгөрсөн оны таамаглалын хувьд бага зэрэг эерүүтэй байгаа хэдий ч бодит байдалд тун дөхөж очсоныг өмнө өгүүлсэн статистикийн мэдээтэй харьцуулж үзэхэд андашгүй харагдах болно.

Японы эдийн засгийн үзүүлэлт

/Жилийн өөрчлөлтийн хувиар болон ажиллах хүчинд эзлэх/

	2001	2002	2003	2004
Бодит ДНБ	0.4	0.2	2.0	1.4
Инфляц	-0.7	-0.9	-0.3	-0.6
Ажилгүйдэл	5.0	5.4	5.5	5.4

Дээрх таамаглалаас үзэхэд энэ оны хувьд ДНБ-ий хэмжээ өнгөрсөн оныхоос буурах хандлагатай байх аж. Түүнчлэн инфляц, ажилгүйдлийн хувьд ч төдийлөн нааштай үзүүлэлт харагдахгүй байна. Дэлхийн банкны судалгааны энэ таамаглалыг хойно гарах The Economist сэтгүүлийн таамаглалтай харьцуулж үзнэ үү.

Японы эдийн засагт өөдрөг байдал ажиглагдаж эхэлсэн хэдий ч нийт улс орны хэмжээнд өрнүүлж буй бүтцийн шинэчлэлт удааширалтай хэвээр, эрс огцом өөрчлөлт дутагдсаар байгааг шинжээчид тэмдэглэж байна. Үүний улмаас үндэсний эдийн засаг бүхэлдээ сэргэхэд ихээхэн хугацаа шаардана гэж судлаачид үзэж байна. Японы эдийн засаг тогтворгүй дээш доош хэлбэлзсээр байгааг Никкэй хөрөнгийн биржийн индекс харуулж байна. Өнгөрсөн оны эцсээр тус хөрөнгийн биржийн индекс 0,23 хувиар унасан явдал үүнийг гэрчилнэ.

БНХАУ

БНХАУ-ын хувьд 2003 он эдийн засгийн эрчимтэй хөгжил улам түргэссэн жил болж өнгөрлөө. SARS өвчин гарч эдийн засагт нь зарим сөрөг нөлөө үзүүлсэн хэдий ч жилийн дүнгээр Хятад улс ДНБ-ийнхээ өсөлтийг 9,1%-д хүргэж чадсан нь сүүлийн 7 жилд байгаагүй өндөр үзүүлэлт боллоо. Хятадын Засгийн газраас 2003 онд ДНБ-ий өсөлтийг 7%-д хүргэхээр дэвшүүлсэн зорилтоос бодит байдал ийнхүү хол давлаа. Өнгөрсөн онд эдийн засгийн өсөлтийг хангахад нөлөөлсөн гол салбарууд гэвэл уул уурхай, үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалт, хэрэглээ, гадаад худалдаа зэрэг байлаа. Өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад уул уурхайн үйлдвэрлэл 12,6%-иар, өндөр технологийн аж үйлдвэр 20,6%-иар, эрчим хүчний үйлдвэрлэл 15,5%-иар, нүүрсний олборлолт 15,0%-иар, түүхий нефть олборлолт 1,8%-иар, гангийн үйлдвэрлэл 25,3%-иар, автомашины үйлдвэрлэл 22,0%-иар, барилгын үйлдвэрлэл 11,9%-иар тус тус өсчээ. Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын салбарын өсөлт оны дүнгээр 26,7%-д хүрчээ. БНХАУ-д “Хөх нуур Төвдийг холбосон төмөр зам тавих төсөл”, “Баруун бүс нутгийн ус, нүүрсний баялагт түшиглэн эрчим хүч үйлдвэрлэж, зүүн бүс нутагт дамжуулах төсөл”, “Баруун бүс нутгаас зүүн бүс нутагт хий дамжуулах хоолой татах төсөл”, “Өмнөд бүс нутгийн усыг хойш татах (Хөх мөрөн хавийн усны нөөц ихтэй нутгаас Шар мөрөн хавийн ус дутагдалтай нутагт ус нийлүүлэх төсөл)” зэрэг томоохон төслүүдийн хэрэгжилтийн явц амжилттай өрнөв. Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын салбарт орон сууцны салбарын хөрөнгө оруулалт өндөр байгаа бөгөөд

том хотууд дахь орон сууцны борлуулалтын хэмжээ 2001, 2002 онд 2 жил дараалан өмнөх оныхоос 20%-иар өндөр өсөлттэй байснаа, 2003 онд улмаар 34,1% болж нэмэгджээ. Үүнд нийт дүнгийн 90%-тай тэнцэх хэмжээний орон сууцыг хувь хүмүүс худалдаж авсан байна. Жижиглэн худалдаалсан бараа бүтээгдэхүүний үнийн дүнгийн өсөлт 9,1%-д хүрчээ. Хүн амын цалин хөлс нэмэгдэж худалдан авах чадвар сайжирснаар автомашин, мэдээлэл холбооны хэрэгсэл, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, тавилгын борлуулалт урьд өмнөх жилүүдээс нэмэгджээ.

Гадаад худалдааны нийт дүн 2003 онд 851 тэрбум 200 сая ам. долларт хүрч, өмнөх оныхоос 37,1%-иар өсчээ. Экспорт 34,6%-иар, импорт 39,9%-иар тус тус нэмэгдэж, гадаад худалдааны балансын ашиг 25 тэрбум 600 сая ам. долларт хүрчээ. Үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж эрчим хүч, түүхий эдийн эрэлт хэрэгцээ ихэссэн нь импорт их хэмжээгээр нэмэгдэх гол нөхцөл болжээ. Худалдааны гол түнш орнууд гэвэл экспортод ОХУ /өмнөх оныхоос 71,4%-иар өссөн/, Европын холбоо /өмнөх оныхоос 49,7%-иар өссөн/ бөгөөд импортын хувьд ASEAN /өмнөх оныхоос 51,7% өссөн/, БНСУ /өмнөх оныхоос 51,0%-иар өссөн/ зэрэг юм. Хятадын гадаад худалдааны гол түнш Японтой хийсэн худалдааны экспорт 59 тэрбум 400 сая доллар /өмнөх оныхоос 22,7%-иар өссөн/, импорт 74 тэрбум 200 сая доллар /өмнөх оныхоос 38,7%-иар өссөн/ боллоо. БНХАУ ДХБ-ын үндсэн зарчимд тулгуурлаж, зах зээлээ нээж, гаалийн татварыг багасган, гадаад худалдааны бичиг баримт бүрдүүлэлтийг хялбарчилсан зэрэг цэгцтэй арга хэмжээ авсны үр дүнд гадаад худалдаа ийнхүү үлэмж хэмжээгээр өсчээ.

Хятадын Засгийн газар 2003 оны гуравдугаар сард газар тариалангийн, санхүүгийн, үйлдвэрийн газрын, засгийн газрын бүтцийн шинэчлэл гэсэн шинэтгэлийн бодлого явуулах шийдвэр гаргалаа. Эдгээрээс газар тариалангийн асуудлыг цухас өгүүлье. Өнөөгийн өндөрлөг, хүрсэн түвшинээс авч үзэхэд Хятадын тариачид, газар газар тариалангийн асуудал нийгмийн хамгийн тулгамдсан хурц асуудлын нэг болоод байна. Энэ асуудлыг шийдвэрлэх үүднээс Хятадын засгийн газар энэ оны эхээр газар тариалангийн салбарт авч явуулах шинэчлэлийн асуудлыг иж бүрнээр тусгасан “Анхдугаар баримт бичиг” гаргалаа. Энэ баримт бичигт хүнсний бүтээгдэхүүний тээвэрлэлт, борлуулалтын систем, тариачдад тэтгэмж олгох арга хэлбэр, газар тариалангийн үйлдвэрлэлд бүтцийн зохицуулалт хийх, хөрсний эвдрэлийг зогсоох, хөдөө тосгоны үйлдвэрлэлийн бүтцэд шинэчлэл хийх, хөдөөгийн жижиг хот сууринг хурдацтай хөгжүүлэх, газрын үршил шим

муудсанаас амьдралаа залгуулах боломжгүй болж хөдөө тосгоноос хөлсний хөдөлмөр эрхлэхээр томоохон хот суурин бараадан нүүж буй тариачдыг нийгмийн хамгаалалтад авах, тэдний дунд сургалт явуулах, ажил олгох, газар тариалан дагнан эрхэлж буй хөдөө тосгонд боловсролын зардлыг төрөөс даах, тариачдын орлогыг нэмэгдүүлэх, хот тосгоны ялгааг аажмаар багасгах зэрэг тариачдын өмнө тулгарсан нийгмийн хурц асуудлуудыг шийдвэрлэхэд төрөөс баримтлах бодлогыг тусгажээ. Дээрхи зорилтыг хэрэгжүүлэх ажил одоо Хятадын газар тариалангийн бүс нутагт эрчимтэй өрнөж эхлээд байна.

Хятадын эдийн засаг сүүлийн жилүүдэд хэрхэн өсч ирснийг дараах хүснэгтээс үзнэ үү.

Хятадын эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтүүд (1998-2003 он)

	1998 он	1999 он	2000 он	2001 он	2002 он	2003 он
ДНБ-ий өсөлт %	7,8	7,1	8,0	7,3	8,0	9,1
Уул уурхайн үйлдвэрийн өсөлт %	10,8	8,9	9,9	8,9	/12,6/	/12,5/
Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын өсөлт %	13,9	6,3	9,3	12,1	/16,1/	/26,7/
Өргөн хэрэглээний барааны жижиглэн худалдааны үнийн дүнгийн өсөлт %	6,8	6,8	9,7	10,1	8,8	9,1
Өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт %	▲0,8	▲1,4	0,4	0,7	▲0,8	1,2
Гадаад худалдааны эргэлт Зуун сая \$	436	291	241	226	304	256
Экспортын өсөлт %	0,6	6,1	27,8	6,8	22,3	34,6
Импортын өсөлт %	▲1,5	18,2	35,8	8,2	21,2	39,9
Гадаадын шууд хөрөнгө оруулалтын өсөлт /гэрээнд тусгагдсан хэмжээ/ %	▲30,4	▲18,9	50,8	10,4	19,6	39,0
/хэрэгжилтийн дун/ %	0,5	▲9,7	0,9	14,9	12,5	1,4
Гадаад валютын нөөц Зуун сая \$	1,450	1,547	1,656	2,122	2,864	4,033

Эх сурвалж: ERINA REPORT. № 2 Vol. 55, 2003. December

Дээрхи хүснэгт энэ их гүрний эдийн засгийн өсөлтийн гол гол үзүүлэлтүүд үнэхээр өргөн далайцтай өсөн нэмэгдэж ирснийг харуулж байна. Нөгөө талаар Хятадын удирдагчид глобалчлалын ашиг тусыг соргоогоор мэдэрч түүнийг улс орныхоо эдийн засгийн хөгжилд чадамгай ашиглаж байгаагийн нэгэн баталгаа гэж үзэж болох юм. Хятад улсын хэмжээнд эдийн засгийн өсөлт ийм байхад бидний тухайлан сонирхож буй Хятадын зүүн хойт гурван мужийн эдийн засгийн хөгжил хэр зэрэг явж ирснийг одоо авч үзье.

Зүүн хойт гурван муж

Зүүн хойт гурван мужийн эдийн засаг оны сүүлийн хагаст эрчимтэй өсч, өсөлтийн хувь улсын дунджаас дээгүүр байлаа.

Ляонин мужид үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеийнхээс 26.5%-иар, уул уурхай, аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 18.2%-иар тус тус өссөн нь эдийн засгийн өсөлтөд чухал хүчин түлхэц болж өгчээ. SARS-аас сэргийлэх зориулалттай олон нийтийн эрүүл ахуйн дэд бүтцийн байгууламжийн хөрөнгө оруулалт өргөжлөө. Аж үйлдвэрийн салбарт машин техник, электрон тоног төхөөрөмж, барилгын материалын үйлдвэрлэлийн өсөлт өндөр хэмжээнд байв. Ляонин мужид 2003 онд Япон улсын соёлын өдрүүд, БНСУ-ын соёлын өдрүүд, Тайваний соёлын өдрүүдийг амжилттай зохион байгуулж эдийн засгийн гадаад хамтын ажиллагаа идэвхижсэн байна. Гадаад худалдааны хувьд экспортын шинэ зах зээлийг өргөжүүлэн машин техник, электрон бараа, өндөр технологийн бүтээгдэхүүн экспортын голлох хувийг эзлэх болжээ. Ялангуяа софт программын экспорт эрчимтэй өслөө. Гадаад худалдааны нийт хэмжээ өмнөх оныхоос 16.0%-иар, шууд хөрөнгө оруулалтын хэмжээ /хэрэгжсэн дүнгээр/ 38.2%-иар тус тус өсчөө.

Гирин мужийн эдийн засгийн өсөлтөд нөлөөлсөн хүчин зүйлс нь мөн л уул уурхай, аж үйлдвэрийн үйлдвэрлэл байв. Эдийн засгийн өсөлт өмнөх оныхоос 19.5%-иар өндөр байв. Ялангуяа автомашины үйлдвэрлэл, нефть боловсруулах үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах үйлдвэрлэл гэсэн гурван гол үйлдвэрлэлд ихээхэн ахиц гарсан байна. 2003 онд Хятад улсын хэмжээнд 3 сая 910 мянга гаруй автомашин борлуулсан нь өмнөх оныхоос 31.3%-иар өссөн үзүүлэлт юм. Үүнд БНХАУ-ын автомашины тэргүүлэх үйлдвэр болох Гирин мужийн автомашины үйлдвэрийн нэгдүгээр нэгдлийн хувь нэмэр чухал байрыг эзэлнэ. Гирин мужийн гадаад худалдаа эрчимтэй өргөжиж, өсөлт нь өмнөх оныхоос 62.9%-иар өндөр байгаа нь Хөх нуур муж /99.0%/, Шинжаан Уйгурын ӨЗО /75.1%/ -ны дараа 3 дугаарт орох үзүүлэлт боллоо.

Хармөрөн мужийн эдийн засагт 10.1%-ийн өсөлт гарлаа. Энэ мужид нефть хими, техникийн бараа, хүнсний бүтээгдэхүүн гэсэн гурван гол үйлдвэрлэл эрчимтэй хөгжлөө. Гадаад худалдааны хувьд, SARS-ын нөлөө байсан хэдий ч, оны сүүлийн хагаст эрчимтэй өслөө. Ялангуяа компьютер, түүний эд анги үйлдвэрлэл өнгөрсөн оныхоос 920%-иар өсч, асар их амжилт олжээ. Түүнчлэн эрдэнэ шиш өмнөх оныхоос 162% өссөн явдал хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортийн хэвийн өсөлтөд чухал хүчин түлхэц үзүүлжээ. Хармөрөн мужийн гадаад худалдааны түнш гол 5 орон нь ОХУ, Япон, Өмнөд Солонгос, Америк,

Герман бөгөөд ОХУ-тай хийж буй худалдааны хэмжээ дээрх таван улстай хийж буй нийт худалдааны 56%-ийг эзэлж байна.

БНХАУ-ын Төв Засгийн газраас Зүүн хойт бүс нутгийг чухалчлан үзэж, бүс нутгийн хөгжлийг дэмжих бодлого баримталж байна. Хятадын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэн Зябао 2003 онд 3 удаа зүүн хойт бүс нутгаар айлчилж, “Зүүн хойт бүс нутгийн уламжлалт аж үйлдвэрийн бааз районыг сэргээн хөгжүүлнэ. Баруун бүсийг нээн хөгжүүлэх стратеги нь баруун зүүн хоёр тэнхлэгт түшиглэнэ” хэмээн цохон тэмдэглэсэн. 10 дугаар сард хуралдсан ХКН-ын Төв Хорооны 16 дахь удаагийн 3 дугаар бүгд хурлаар Зүүн хойт бүс нутгийг хөгжүүлэх асуудлыг хэлэлцэж Төрийн Зөвлөлөөс “Баруун бүс нутгийг нээн хөгжүүлэх төслийн удирдах комиссын ажлын хэсэг”-ийг байгуулсан загвараар “Зүүн хойт бүс нутгийн уламжлалт аж үйлдвэрийн бааз районыг сэргээн хөгжүүлэх үйл ажиллагааг удирдах комиссын ажлын хэсэг”-ийг байгуулсан юм.

Одоогоор Төв Засгийн газраас Зүүн хойт бүс нутгийн давуу талыг түшиглэн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, үндсэн түүхий эдийн боловсруулалт, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын чиглэлийн нийт 61 тэрбум юаний хөрөнгө оруулалттай 100 төслийг сонгон хэрэгжүүлж эхлээд байна. Засгийн газрын хүчирхэг дэмжлэг бүхий эдгээр төслүүдэд дотоод, гадаадын олон үйлдвэр компаниуд оролцох саналаа илэрхийлж, Зүүн хойт бүс нутгийн хэмжээнд ч ихээхэн талархалтайгаар хүлээн авчээ.

2003 оны 10-р сарын 15-нд Хятад улсын түүхэнд анх удаа хүн суулгасан сансрын хөлөг амжилттай хөөргөлөө. Ингэснээр БНХАУ нь ОХУ, АНУ-ын дараа хүн суулгасан сансрын хөлөг амжилттай хөөргөсөн дэлхийн гурав дахь орон боллоо. Энэ том үйл явдалд Хятадын Зүүн хойт бүс нутгийнхан онцгой үүрэг гүйцэтгэсэн байна. Тодруулж хэлбэл энэ төслийн ерөнхий удирдагч, сансрын хөлгийн зохион бүтээгч хоёулаа Харбины Аж үйлдвэрийн их сургуулийн эрдэмтэд бөгөөд уг хөлгийг энэ их сургуульд бүтээснээр зогсохгүй, Хятад улсын анхны сансрын нисэгч нь Ляонин мужийн уугуул иргэн ажээ. Ийнхүү энэ 3 муж Хятад улсын төдийгүй ЗХА-ийн эдийн засгийн интеграцид ихээхэн чухал үүрэг гүйцэтгэх хандлагатай болж эхэллээ. Гурван мужийн эдийн засгийн гол гол үзүүлэлтүүдийг дараах хүснэгтээс харна уу.

Хятадын зүүн хойт мужийн эдийн засгийн үзүүлэлтүүд (2001-2003)

	2001 он				2002 он				2003 он			
	Хятад улс	Ляонин	Гирин	Хар мөрөн	Хятад улс	Ляонин	Гирин	Хар мөрөн	Хятад улс	Ляонин	Гирин	Хар мөрөн
GDP-ийн өсөлт %	7.3	9.0	9.3	9.3	8.0	10.2	9.5	10.3	8.5	-	9.5	10.1
Уул уурхайн үйлдвэрлэлийн өсөлт %	8.9	10.8	15.1	9.5	10.2	9.2	18.6	11.0	16.8	18.2	19.5	13.7
Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын өсөлт %	12.1	11.9	15.8	14.3	16.1	13.0	18.4	11.5	29.6	26.5	22.8	12.3
Өргөн хэрэглээний барааны жижиглэн худалдаалсан үнийн дүнгийн өсөлт %	10.1	10.1	11.8	9.6	8.8	11.0	10.9	10.1	8.9	-	9.1	-
Гадаад худалдааны эргэлт зуун сая \$	226.0	23.1	▲2.1	1.6	304.0	30.0	▲1.5	▲3.7	197.5	20.3	▲18.6	2.0
Экспортын өсөлт %	6.8	2.4	16.3	15.4	22.3	12.4	21.0	23.3	32.9	16.0	15.8	35.2
Импортын өсөлт %	8.2	7.7	27.1	11.1	21.2	6.6	11.1	33.2	39.1	26.6	103.7	4.3

Эх сурвалж: ERINA REPORT. Vol. 56, 2004. February

Дээрх үзүүлэлтээс Хятадын зүүн хойт 3 мужийн эдийн засаг бүс нутгийн интеграцын хөгжлийг тодорхойлох шинжийг агуулан хөгжиж байна уу гэх сэтгэгдэл төрж байна. Мужууд Хойд Солонгос, ОХУ-тай шууд хиллэж бүтээгдэхүүнээ энэ хоёр улсад экспортлох, хамтрах, хорших чиглэлд стратегийн чухал ач холбогдол өгөн төр засгаас нь онцгой анхаарч байгаа нь үүнийг гэрчилнэ.

Хятад улс энэ оны 3 сард хуралдсан БХАТХ-ын X их хурлын хоёрдугаар чуулганаараа Үндсэн хуулиндаа өөрчлөлт оруулж хувийн өмчтэй байхыг хүлээн зөвшөөрч хуульчлан баталгаажуулсан явдал мөн л дэлхийн хөгжлийн чиг хандлагыг соргоогоор тусган авч улс орныхоо эдийн засгийг улам бүр либералчилж нээлттэй болгож байгаагийн нэгэн илрэл боллоо. Энэ түүхэн чухал шийдвэр нь их Хятадын эдийн засгийн өсөлт хөгжлийг улам бүр түргэтгэж, ард түмнийх нь амьдралын өнөөгийн хүрсэн түвшинг эрс дээшлүүлэх чиглэлд нэгэн чухал хүчин зүйл болох нь дамжиггүй.

ОХУ

2003 онд ОХУ-ын ДНБ-ий өсөлт 7.3%-д хүрч, 2000 оноос хойшхи хамгийн өндөр үзүүлэлттэй жил болов. ОХУ-ын эдийн засгийн өсөлт эрчим хүчний баялгийн экспортын байдлаас ихээхэн хамааралтай хэвээр байгаа бөгөөд 2003 оны эдийн засгийн өсөлтийн дотор 2%-тай тэнцэх хэсэг нь Оросын түүхий нефтийн үнэ өссөнтэй холбоотой ажээ.

Уул уурхайн үйлдвэрлэлийн өсөлтийг салбар тус бүрээр авч үзэх юм бол Оросын эдийн засгийн амин сүнс гэгддэг түлш эрчим хүчний үйлдвэрийн салбарт хамгийн их өсөлттэй /өмнөх оныхоос 9.3%-иар нэмэгдсэн/ байна. Бусад салбаруудаас болд гангийн үйлдвэрлэл 8.9%-ийн, техникийн болон металл боловсруулах үйлдвэрлэл 9.4%-ийн өсөлттэй байлаа. Ган хоолойн үйлдвэрлэл, олборлох үйлдвэрлэл, вагон үйлдвэрлэлийн хэмжээ эрчимтэй өсч, эдгээр салбаруудад хөрөнгө оруулалт идэвхжсэн байна.

Бодит цэвэр орлогын хэмжээ 14.6% өсч, ОХУ бий болсноос хойш хамгийн өндөр өсөлтэй байв. Мөн жижиглэн худалдаалсан барааны үнийн дүн болон үйлчилгээний салбарын борлуулалтын хэмжээ /5.1%/ ч нэмэгдсэн байна. Нөгөө талаар мөнгөн орлогын тоон үзүүлэлтийг анхааралтай ажиглавал Оросын бүс нутгуудын хооронд орлогын ялгаа ихэсч ирснийг харж болно. 2002 оны байдлаар Москвагийн хүн ам тутамд оногдох мөнгөн орлогын хэмжээ нийт улсын дунджаас 2.6 дахин их байсан бол 2003 онд 4.0 дахин их болж ялгаа нь бараг 2 дахин нэмэгджээ. Мөн хугацаанд Алс Дорнодын бүс нутгийн хүн амын орлого 1.08 дахин их байснаа 1.04 дахин их болж ялгаа нь буурчээ. Энэ мэтчилэн угаас хүн амын орлогоороо эрс ялгаатай байсаар ирсэн Москва болон бусад бүс нутгийн орлогын ялгаа улам ихсэх хандлагатай байна. Сүүлийн хэдэн жилд Москвагийн оршин суугчид “Москвагаас бусад нь Орос биш”, харин бусад бүс нутгийнхан “Москва бол Орос биш” гэлцэн мэтгэлцэх хандлага гүнзгийрсээр байна.

Жилийн инфляци 12.0%-тай байгаа нь үүний өмнө инфляци хамгийн бага байсан 1997 оны 11.0%-ийн дараа орох хамгийн бага түвшин бөгөөд 2003 онд ОХУ-ын эдийн засаг энэ улс байгуулагдсанаас хойш хамгийн сайн байлаа гэж дүгнэж болохоор байв. Оросын эдийн засгийн сүүлийн хэдэн жилийн үзүүлэлтийг дараах хүснэгтээс үзнэ үү.

ОХУ-ын эдийн засгийн үзүүлэлтүүд (2000-2003)

	2000 он	2001 он	2002 он	2003 он
ДНБ-ий өсөлт %	10.0	5.1	4.7	7.3
Уул уурхайн үйлдвэрлэлийн өсөлт %	11.9	4.9	3.7	7.0
Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл %	7.0	6.8	1.7	1.5
Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалт %	17.4	8.7	2.6	12.5
Жижиглэн худалдаалах үнийн нийт дүн %	8.7	10.8	9.2	8.0
Хэрэглээний үнийн өсөлт %	20.2	18.6	15.1	12.0
Бодит орлого %	9.3	5.8	9.9	14.6
Ажилгүйдэл %	10.5	9.0	8.0	8.3
Гадаад худалдааны баланс /тэрбум ам доллар/	60.17	48.12	46.34	59.99
Урсгал баланс /тэрбум ам.доллар/	46.84	33.57	29.52	39.10
ОХУ-ын санхүүгийн баланс %	2.2	3.0	1.8	1.7

ОХУ /Алс Дорнод/

ОХУ-ын Алс Дорнодын бүс нутгийн эдийн засгийн байдал 2003 онд ерөнхийдөө эерэг өсөлтийн хандлагатай байсан хэдий ч, уул уурхайн үйлдвэрлэлийн өсөлт урьд жилүүдийнхээс буурч 3.7%-тай байсан нь ОХУ-ын эдийн засгийн 7 бүсийн дотор хамгийн доогуур байр эзэлж ирсэн урьдын үзүүлэлтийг өөрчилж чадсангүй. Салбаруудаар ангилж үзвэл загас, далайн бүтээгдэхүүн /27.2%/, түүхий нефтийн анхан шатны боловсруулалт /24.3%/ зэрэг өндөр өсөлттэй салбар ч байгаа юм. Гэвч цаасны үйлдвэрлэл, нефть байгалийн хий, техникийн үйлдвэрлэл, хүнс ундааны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл уналтын байдалтай байв. Мужуудаар авч үзвэл, Магадан муж болон Сахагийн Бүгд Найрамдах Улсад үйлдвэрлэл -9.0%, -0.2%-иар унасан байна. Харин Еврейн автономит тойрог /15.0%/, Чукотын өөртөө засах тойрог /10.5%/ зэрэгт үйлдвэрлэл онцгой өсөлттэй байв.

Уул уурхайн үйлдвэрлэл нийт улсын түвшингээс доогуур байгаа хэдий ч, өрхийн бодит орлогын хэмжээ, жижиглэн худалдаалсан үнийн дүнгийн өсөлт улсын дунджаас бага зэрэг дээгүүр байна. Өрхийн орлогын хувьд улсын дундаж өсөлт /13.3%/-өөс үлэмж дээгүүр өсөлттэй байгаа муж гэвэл Саха Бүгд Найрамдах Улс /24.5%/, Амур муж /22.1%/, Сахалин муж /21.3%/ юм. Хөдөлмөр эрхлэлтийн хувьд улсын хэмжээнд нийт ажилгүйчүүдийн тоо 12.5%-иар нэмэгдсэн байхад Алс Дорнодод энэ тоо 0.2%-иар буурсан байна. Ялангуяа Сахалин муж, Еврейн автономит тойрог, Чукотын автономит районд хөдөлмөр эрхлэлт нэлээд эерэг үзүүлэлттэй байв. Харин Амур муж, Саха Бүгд Найрамдах Улсад ажилгүйчүүдийн тоо өсчээ. Алс Дорнодын бүс нутгийн эдийн засгийн үзүүлэлтийг дараах хүснэгтээс үзнэ үү.

Алс Дорнодын бүс нутгийн эдийн засгийн үзүүлэлт

	Уул уурхайн аж үйлдвэрлэл/2003о ны 1-10-р сар өмнөх оны мөн үетэй харьцуулахад/	Жижиглэн худалдаалсан үнийн дүн /2003 оны 1-10-р сар, өмнөх оны мөн үетэй харьцуулахад/	Хэрэглээний үнэ / 2003 оны 10-р сар, өмнөх оны 12-р сартай харьцуулахад/	Бодит мөнгөн орлого /2003 оны 9-р сар, өмнөх оны 9-р сартай харьцуулахад/	Ажилгүйчүүди йн тоо /2003 оны 9-р сар, өмнөх оны мөн үетэй харьцуулахад/
Саха БНУ	▲0.2	20.6	9.8	24.5	7.0
Примор	7.0	12.1	9.9	9.1	1.6
Хабаровск	2.9	5.4	12.0	10.9	▲2.0
Амур	6.1	5.6	12.5	22.1	12.3
Камчатка	6.3	2.9	7.9	11.4	1.3
Магадан	▲9.0	12.3	9.0	9.2	▲6.0
Сахалин	3.8	11.4	9.3	21.3	▲27.3
Еврейн автономит	15.0	3.6	11.0	▲4.3	▲15.4
Чукотка	10.5	9.3	11.4	3.5	▲11.1
Алс Дорнод	3.7	10.8	10.0	15.0	▲0.2
ОХУ	6.8	8.1	9.7	13.3	12.5

2003 оны 12 дугаар сарын 5-нд Сибирийн төмөр замын хойд талаар зэрэгцэн баригдсан Байгал-Амурын төмөр зам /БАМ/-ын Северомуйскийн хонгил зам ашиглалтанд орж, анхны галт тэрэг /Находка-Петербургийн хоорондын/ явж өнгөрөв. 15343 м урттай, дэлхийд уртаараа 5-рт орох, ОХУ-даа бол хамгийн урт энэ хонгил зам ашиглалтанд орсноор БАМ-ын төмөр зам баригдаж дууслаа. БАМ-ын төмөр зам анх 1984 онд ашиглалтанд орсон бөгөөд өнөөг хүртэл Северомуйскийн нуруу /Бүгд Найрамдах Буриад Улсын хойд хэсэг/-ны түр ашиглах зориулалтын тойруу шугамаар галт тэрэг зорчиж байсан юм. Хөрсний ус, газар хөдлөлт ихтэй, цаг уурын хувьд бэрхшээлтэй, бүс нутагт баригдсан энэ хонгил зам технологийн хувьд ихээхэн нарийн байгууламж болохын зэрэгцээ 1990-ээд оны эдийн засгийн хямралын шалтгаанаар хөрөнгө оруулалт бараг зогсож, бүрэн баригдах хүртлээ ийнхүү бүтэн 26 жилийн хугацаа шаарджээ.

1995-2002 онд Сибирийн төмөр зам болон БАМ-ын төмөр замын ачаа тээврийн хэмжээ 35%-иар нэмэгдэж, 61 сая 700 мянган тонн-д хүрчээ. Ачаа тээврийн хэмжээ 2010 он гэхэд улмаар 30%-иар нэмэгдэх төлөвтэй байгаа бөгөөд 2004 он гэхэд л Сибирийн төмөр замаас БАМ-ын төмөр замд 6 сая тонн ачаа тээвэрлэлт шилжиж ирэхээр Оросын Төмөр зам компани тооцоолжээ.

БАМ-ын төмөр замын дагуух бүс нутагт 70 гаруй ашигт малтмалын орд газар илэрчээ. Зөвхөн Бүгд Найрамдах Буриад улсад гэхэд л ОХУ-ын хэмжээний цайрын агууламжийн 32%, хар тугалганы 24%, гянт вольфрамын 27%, молибдений 37% нь оршиж байна. Мөн нефть, нүүрсний томоохон орд газрууд ч бий. Ойрын ирээдүйд эдгээр баялагийг олборлох зорилт тавьж байна. Алс Дорнодын бүс нутагт БАМ-ын төмөр зам байнгын ашиглалтад орсон явдал Оросын болон бүс нутгийн эдийн засгийн өсөлт хөгжлийг түргэтгэхэд асар их үүрэг гүйцэтгэх нь дамжиггүй.

БНСУ

Өмнөд Солонгосын эдийн засаг 2003 оны 4-р улиралд эсрэг өсөлтөд хүрч өмнөх 3 улирал дараалсан уналтыг зогсоож чадлаа. Боловсруулах аж үйлдвэрийн үйлдвэрлэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 дугаар улиралд 3.1%, 4 дүгээр улиралд 8.3%-ийн өсөлттэй байв. Дотоодын хэрэглээ 0.8%-иар өсч, өмнөх жилийн сөрөг үзүүлэлтээс гарч чаджээ. Ажилгүйдэл 11, 12 дугаар сард 3.5% байсан бол 2004 оны 1 дүгээр сард 3.3% болж ажил эрхлэлтийн байдал

сайжирсан байна. Гадаад худалдааны ашигтай баланстай байгаа бөгөөд энэ үзүүлэлт 2004 оноос улам сайжрах төлөвтэй байна. Харин гадаадын эрэлт хэрэгцээтэй харьцуулахад бөөний болон жижиглэн худалдаалсан барааны дүн зэрэг дотоодын эрэлт хэрэгцээнд хамаарах үзүүлэлтүүд урьдын адил доогуур хэмжээнд байгаа ажээ. Одоогоор дотоодын хэрэглээний царцанги байдлыг гадаад хэрэглээ нөхөх хандлагатай байна.

БНСУ 2003 онд бүс нутгийн болон бусад улстай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах үйл ажиллагааг нэлээд идэвхижүүлж ирлээ. Ерөнхийлөгч асан Ким Дэжуны Японд хийсэн айлчлалын үеэр үндсийг нь тавьсан Өмнөд Солонгос Японы хооронд Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах яриа хэлэлцээг үргэлжлүүлж, Чили улстай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулагдлаа. Энэ хэлэлцээр хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний гаалийн татварыг тэглэхийг эсэргүүцсэн хэсгийнхний хүчтэй эсэргүүцэлтэй тулгарч хэд хэдэн удаа хойшлогдсоны эцэст Парламентаар батлагдлаа.

2003 он улс төрийн хүрээнийхний хувьд мөн л хөдөлгөөн донсолгоотой жил боллоо. Улс төрийн өндөр албан тушаалтнууд тухайлбал Но Мүхён ерөнхийлөгчийн шадар туслахын санхүүгийн SK групптэй холбоотой хээл хахуулийн хэрэг, эрх баригч намын доторхи зөрчил зэргээс болж, Ерөнхийлөгчид итгэл хүлээлгэх, эсэх асуудлаар ард түмний дотор санал асуулга зарлахад хүрч улс төрийн хурцадмал байдал үүссэн юм. Өмнөд Солонгосын эдийн засгийн үзүүлэлтийг дараах хүснэгтээс үзнэ үү.

Өмнөд Солонгосын Эдийн засгийн үзүүлэлт (1999-2003)

	1999 он	2000 он	2001 он	2002 он	2003 он
ДНБ %	10.9	9.3	3.1	6.3	3.1
Хэрэглээний эцсийн зардал %	9.4	6.7	4.2	6.2	-
Боловсруулах аж үйлдвэрийн үйлдвэрлэл %	25.0	17.1	0.9	8.3	4.9
Ажилгүйдэл %	6.3	4.1	3.8	3.1	3.4
Гадаад худалдааны нийт эргэлт /сая \$/	28.371	16.872	13.492	14.180	14.180
Экспорт /сая \$/	143.686	172.268	150.439	162.471	194.325
Импорт /сая \$/	119.752	160.481	141.098	152.126	178.784
Ханш /вон/US \$/	1.190	1.131	1.291	1.251	1.192
Үйлдвэрлэгчийн үнэ%	▲2.1	2.0	▲0.5	▲0.3	2.2
Хэрэглээний үнэ%	0.8	2.3	4.1	2.7	3.6
Акцийн үнэ/1980.1.04-нийг 100 гэж үзэв/	807	734	573	757	680

Эх сурвалж: ERINA REPORT. Vol. 56. 2004, February

БНАСАУ

БНАСАУ 2002 оноос эдийн засгийн шинэчлэлд чиглэсэн хэд хэдэн арга хэмжээг авч явууллаа. 2002 оны 7-р сард эдийн засгийн удирдлагыг сайжруулах талаар, 2003 оны 3-р сард улс орны эдийн засгийг зах зээлийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх талаар шийдвэр

гаргасан юм. Эдгээр цуврал арга хэмжээ нь ард түмний ахуй амьдрал нийгмийн асуудлыг сайжруулахад зохих нөлөө үзүүлж ирлээ. Хойд Солонгосын эдийн засгийн талаар статистик мэдээ ховор байдаг хэдий ч Өмнөд Солонгосын Bank of Korea энэ орны эдийн засгийн хөгжлийн 11 жилийн явц байдлын талаар нэлээд чухал мэдээлэл нийтэлжээ. Хэдийгээр 2001 оноос хойшхи үзүүлэлт энд ороогүй ч гэсэн бид энэ орны эдийн засгийн ерөнхий байдлын талаар тодорхой ойлголт авч чадахаар байгаа тул түүнийг энд танилцуулж байна.

БНАСАУ-ын Эдийн засгийн гол үзүүлэлтүүд (1991-2001 он)

Үзүүлэлт	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001
Хүн ам /Мян /	20 495	20 798	21 123	21 353	21 543	21 648	21 810	21 942	22 085	22 175	22 253
ДНБ/US\$ тэрбум/	22.9	21.1	20.5	21.2	22.3	21.4	11.7	12.6	15.8	16.8	15.7
Хүн ам тутамд ногдох ДНБ US\$	1 115	1 013	969	992	1 034	989	811	573	714	757	706
ДНБ ийн өсөлт %	▲5.2	▲7.6	▲4.3	▲1.7	▲4.5	▲3.7	▲6.8	▲1.1	6.2	1.3	3.7
Улсын тасви	Орлого /US\$ тэрбум/	17.30	17.50	18.53	19.27	11.85	9.49	9.13	9.00	9.12	9.54
	Зарлага /US\$ тэрбум/	17.17	17.39	18.38	19.19	11.80	9.63	9.13	9.10	9.22	9.57
Хувьд аа	Экспорт /A/ /US\$ тэрбум/	1.12	1.19	1.20	1.02	0.96	0.91	1.10	0.65	0.64	0.72
	Импорт /B/ /US\$ тэрбум/	1.82	1.80	1.81	1.46	1.60	1.50	1.58	1.01	1.18	1.68
	Нийт хувьдлага /A+B/ /US\$ тэрбум/	2.94	2.99	3.01	2.48	2.56	2.41	2.68	1.66	1.82	2.40
	Хувьдлаганы тэнцэл /US\$ тэрбум/	▲0.60	▲0.61	▲0.61	▲0.44	▲0.64	▲0.59	▲0.48	▲0.36	▲0.54	▲0.92
	ДНБ-нд гадаад хувьдлаганы зээл хувь	12.4	14.2	14.7	11.7	11.5	11.3	15.1	13.2	11.5	14.3
Хувьдлаганы гол түвшин	Хятад	Экспорт /US\$ тэрбум/	86	156	297	199	64	69	112	57	42
		Импорт /US\$ тэрбум/	525	541	620	425	486	497	535	356	329
		Хувьдлаганы нийт дүн /US\$ тэрбум/	611	697	900	624	550	566	656	413	370
		Хувьдлаганы тэнцэл /US\$ тэрбум/	▲439	▲386	▲305	▲225	▲423	▲428	▲413	▲298	▲287
	Орос	Экспорт /US\$ тэрбум/	171	65	40	40	16	29	17	8	2
		Импорт /US\$ тэрбум/	194	227	188	100	68	36	67	57	49
		Хувьдлаганы нийт дүн /US\$ тэрбум/	365	292	227	140	83	65	84	65	50
		Хувьдлаганы тэнцэл /US\$ тэрбум/	▲23	▲162	▲148	▲60	▲52	▲7	▲50	▲48	▲47
	Япон	Экспорт /US\$ тэрбум/	284	257	252	323	340	291	310	219	203
		Импорт /US\$ тэрбум/	224	223	220	171	255	227	179	175	148
		Хувьдлаганы нийт дүн /US\$ тэрбум/	508	480	472	494	595	518	489	395	350
		Хувьдлаганы тэнцэл /US\$ тэрбум/	60	34	33	152	85	64	132	44	55
	Өмнөд Солонгос	Экспорт /US\$ тэрбум/	106	163	178	176	223	182	193	92	122
		Импорт /US\$ тэрбум/	6	11	8	18	64	70	115	130	212
		Хувьдлаганы нийт дүн /US\$ тэрбум/	111	174	187	195	287	252	308	222	333
		Хувьдлаганы тэнцэл /US\$ тэрбум/	100	152	170	158	159	113	78	▲37	▲90
Хүрмтлэгдсэн гадаад өр	Нийт дүн /US\$ тэрбум/	93	97	103	107	118	120	119	121	123	125

Тайлбар: Сөрөг үзүүлэлт

Эх сурвалж: Bank of Korea, results of Estimates of DPRK GDP, editions for each year. Supreme People's Assembly of the DPRK, Report of Budget and Account Settlement, editions for each year Korea Trade-Investment Promotion Agency IKOTRA, Trends in rfte DPRK's External Trade Ministry of Unification ROK, Trends in North-South Exchange and Cooperation

Солонгосын Хөдөлмөрийн Нам, Засгийн газраас 2004 онд эдийн засгийг хөгжүүлэх гол зорилтыг тодорхойлж, эдийн засгийн хөгжлийн чөдөр тушаа болж байгаа эрчим хүч, нүүрс, металлургийн үйлдвэр болон төмөр замын тээврийн салбарыг жилийн бүтээн байгуулалтын гол объект болгохоор заажээ. Бусад салбаруудаас олборлох аж үйлдвэр, техник, тоног төхөөрөмж, шинжлэх ухаан, барилгын материалын үйлдвэр болон ойн аж ахуйн салбарт оршиж буй нөөц бололцоог бүрэн дүүрэн дайчлах, хөнгөн аж үйлдвэрийн салбарт технологийн шинэчлэл хийх, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, чанарыг дээшлүүлэх зорилтыг дэвшүүлжээ. Газар тариалангийн салбарт сортыг шинэчлэх, төмсний тариалалт, жилдээ хоёр удаа тариалалт хийх, түүний зэрэгцээ шар буурцаг тариалалт, мал аж ахуйн болон орчин үеийн шувууны фермийг голлосон хөдөө аж ахуйг хөгжүүлэх зорилтыг тэргүүн зэрэгт дэвшүүлжээ. Шинжлэх ухаан технологийг хөгжүүлэх чиг бодлогын тухайд “Шинжлэх ухаан технологийг нийтэд нь ойрын хугацаанд дэлхийн түвшинд гаргаж хөгжүүлэх”-ээр заажээ. Өнгөрсөн хугацаанд Солонгос хоорондын эдийн засгийн харилцаа нэмэгдлээ. Тухайлбал, 2003 онд Солонгос хоорондын худалдаа 406 сая ам. долларт хүрсэн нь 2002 онтой харьцуулахад 45%-иар өссөн байна.

БНАСАУ-ын эдийн засгийн үзүүлэлт (2002-2003)

	2002	2003
ДНБ (%)	1.2	0.7
Экспорт(тэрбум ам.доллар)	1.0	1.5
Импорт(тэрбум ам.доллар)	1.9	2.0
Хүн ам (сая)	22.4	22.5

Эх сурвалж: The Economist. 2003.N●12. The World in 2004

Хойд Солонгосын эдийн засгийн хүндрэл, өлсгөлөнгийн зэрэгцээ түүний улс төрийн тогтолцоо цөмийн хөтөлбөрийн асуудал нь Солонгосын хойгийн болон олон улсын харилцааны хурцадмал байдлын эх үүсвэр болсон хэвээр байна. Солонгосын цөмийн хөтөлбөрийн асуудлаархи 6 талт хэлэлцээрийг бүс нутгийн орнуудын хүчин зүтгэлээр цаашид үргэлжлүүлэхээр тогтсон хэдий боловч 2003 онд удаа дараа хойшлогдож, тодорхой үр дүнд хүрч чадаагүй юм. Зургаан талт яриа хэлэлцээртэй холбогдуулан Хойд Солонгосын тавьж буй шаардлага нь АНУ Хойд Солонгосыг дайсагнан үзэх бодлогоосоо татгалзах, цөмийн хөтөлбөрөөс татгалзах болон Хойд Солонгосын нийгмийн тогтолцооны

аюулгүй байдлын баталгааг бэхжүүлэх “Асуудлыг нэгэн зэрэг шийдвэрлэх тухай зарчим”-ыг хүлээн авах шаардлага юм.

Солонгосын хойгийн цөмийн зэвсгийн асуудлыг 6 талт яриа хэлэлцээний хүрээнд олон улсын харилцааны механизмыг ашиглан, энх тайвнаар шийдвэрлэх нь үнэхээр бүс нутгийн тогтвортой байдал, эдийн засгийн хөгжлийн эрх ашигт бүрэн нийцэх билээ.

Хойд Солонгосын өнөөгийн тогтолцоо нь асар өндөр өртөгтэй тогтолцоо болохыг Хоёр Солонгосын зарим үзүүлэлтийн харьцуулалтаас үзэж болох юм.

Хоёр Солонгосын эдийн засгийн зарим үзүүлэлтийг харьцуулсан судалгаа

	Хүн ам /сая/	Хүн тутамд ногдох ДНБ, ам.доллар	Цэргийн зардал ДНБ-ий хэдэн %	Жил тутам үйлдвэрлэж буй цахилгаан эрчим хүч, тэрбум.кWh	Хүн амын дундаж наслалт
Өмнөд Солонгос	48.3	19400	2.8	273.2	73
Хойд Солонгос	22.2	1000	31.3	33.4	61

Эх сурвалж: CIA World Factbook, 2002, World Bank

Монгол Улс

Гадаад худалдаа, санхүүгийн алдагдал улам нэмэгдсэн хэдий ч, инфляци, ажилгүйдэл, мөнгөний ханш харьцангуй тогтвортой байгаа сүүлийн хэдэн жилийн эдийн засгийн ерөнхий хандлага 2003 онд үргэлжилсэн хэвээр байв. 2003 онд эдийн засгийн бодит өсөлт 5.5%-д хүрч, төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ 1999 оныхоос 2.6 дахин нэмэгдлээ. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 1999 оныхоос 3.7 дахин өслөө. Цаг агаарын байдал ерөнхийдөө тааламжтай байсан нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд нааштайгаар нөлөөлөв. 2003 онд тариалсан нийт талбайн хэмжээ өмнөх оныхоос 20.8%-иар багассан хэдий ч хураасан ургацын хэмжээ 164 мянга 400 тн болсон нь өмнөх оныхоос 31.2%-иар нэмэгдсэн үзүүлэлт боллоо. Мал сүргийн тоо толгой 1999 оноос хойш анх удаа өсч, 25 сая 300 мянган толгойд хүрлээ.

2003 оны санхүүгийн алдагдал 80 тэрбум 700 сая төгрөг болж өмнөх оныхоос 15.3%-иар нэмэгдлээ. Санхүүгийн алдагдлын гол шалтгаан нь зээлийн өр төлөлт, хөрөнгө оруулалтын зарлага болон зээлийн өсөлттэй холбоотой юм. Нэг жишээг дурдвал Засгийн газрын хэрэгжүүлж буй “мянганы зам төсөл”-ийн төрөл бүрийн үйл ажиллагаанд

зориулж замын сангаас гаргасан зарлага 75.1%-иар өссөн байна. Уул уурхайн үйлдвэрлэл өмнөх оныхоос 2.0%-иар өссөн нь, 2002 оны өсөлт 3.8%-ийн тал хувиас хэтэрсэнгүй. Уул уурхайн үйлдвэрлэлийн талаас илүү хувийг эзэлж буй олборлох салбарын үйлдвэрлэл 1.0%-иар буурсан нь нийт үйлдвэрлэлийн өсөлтийг хойш татсан юм. Мөн оёмол сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл өмнөх оныхоос 17.1%-иар буурсан байна. Дэлхийн худалдааны байгууллагын “Сүлжмэл болон сүлжмэл бүтээгдэхүүний /хувцас/ тухай хэлэлцээр” 2004 оны эцсээр хүчингүй болж, Монголд үйлдвэрлэсэн сүлжмэл бүтээгдэхүүнд олгож ирсэн тааламжтай нөхцөл үгүй болж байгаа нь оёмол сүлжмэлийн үйлдвэрлэл буурахад хүргэж байна. Өнөөг хүртэл АНУ болон Европын зах зээлд Монголоос оруулах импортын хэмжээ маш ихээр тогтоогдож, бодит байдал дээр ямар ч хязгаарлалт байгаагүй тул, 1990-ээд оны эхэн үеэс дээрх орнуудад хийх экспорт нь хязгаарлагдаж байсан Азийн улсуудын үйлдвэрүүд Монгол Улсад идэвхтэй хөрөнгө оруулалт хийж, үйлдвэрлэл явуулж байсан юм. Дээр дурдсан хэлэлцээрийн хүчинтэй хугацаа дуусах тун шахаж байгаа яг энэ үед тэдгээр үйлдвэрүүд Монголоос гарч эхэлж байгаа бололтой.

2003 онд гадаад худалдааны нийт хэмжээ өмнөх оныхоос 14.2%-иар нэмэгдэж, 1 тэрбум орчим долларт хүрлээ. Экспорт 14.2%, импорт 14.0%-иар тус тус нэмэгдсэн боловч гадаад худалдааны алдагдал 187.1 сая ам.доллар болж өсчээ.

Монгол Улсын экспортын гол бүтээгдэхүүн болох зэсийн баяжмалын хэмжээ 2.7%-иар нэмэгдсэн боловч, дэлхийн зах зээлийн үнэ өссөн учир экспорт үнийн дүнгээрээ 15.3%-иар нэмэгдсэн байна. Гэсэн хэдий ч гадаад худалдааны алдагдал нэмэгдсэн явдал нь цаашид Монгол Улс нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг оролцуулан экспортын барааны нэр төрлтийг олшруулах, экспортлогч түншээ өргөжүүлэх зэрэг экспортыг хөгжүүлэх хүчин зүтгэл гаргах шаардлагатай байгааг харуулж байгаа юм.

2003 оны эцсийн байдлаар улсын хэмжээнд аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй субъектийн тоо 31500 байгаагаас 60.3% нь нийслэл Улаанбаатар хотод төвлөрч байна. Салбараар авч үзвэл, “бөөний болон жижиглэн худалдаа, автомашин, гэр ахуйн барааны засвар үйлчилгээ” эрхэлж буй субъект хамгийн олон, нийт субъектийн 42.4%-ийг эзэлж, түүний дараа “бүс нутгийн хэмжээний болон хувь хүмүүст зориулсан үйлчилгээ /10.7%/”, “аж үйлдвэр /8.5%/”-ийг тус тус эзэлж байна. 20 хүртэл ажиллагсадтай жижиг дунд үйлдвэр 89.3%-

ийг эзэлж байна. Жижиг дунд үйлдвэрийн тоо өсч буй өнөөгийн байдлаас харахад улс орны эдийн засгийг хөгжүүлэхийн тулд жижиг дунд үйлдвэрийг дэмжих, хөгжүүлэхэд чиглэсэн зохистой арга хэмжээ авах шаардлагатай байна.

2003 оны 5-р сарын 1-нээс “Монгол Улсын иргэдэд газар өмчлүүлэх тухай хууль” хэрэгжиж эхэллээ. Монгол Улсын Засгийн газрын Ерөнхий сайд Н.Энхбаяр 6-р сарын 26-наас 7-р сарын 3-нд ОХУ-д албан ёсны айлчлал хийсэн юм. Айлчлалын үеэр ОХУ-ын Засгийн газар 1990 оноос өмнөх Монгол Улсын хуучин ЗХУ-д төлөх ёстой өрийн 98% /11 тэрбум 400 сая шилжих рубльтэй тэнцэх/-ийг чөлөөлөх шийдвэр гаргасан бөгөөд мөн оны эцэст Монгол улсын засгийн газар ОХУ-д 250 сая ам.доллар нэг дор бөөнөөр нь шилжүүлж их өрийг цайруулсан дуулиант шоу болж өнгөрлөө. Дашрамд тэмдэглэхэд үүнийг зөв буруу гэж үзэхдээ бус дэлхий нийтийн хэмжээнд өнөөдөр ядуу орнуудын өрийг тэглэх талаар гарч буй нааштай хандлага болон **Парисын клубын** нэн буурай, ядуу орнуудын (**Heavily Indebted Poor Countries**) өрийг зохицуулах тусгай хөтөлбөр буюу **Торонто нөхцөл** (1988), **Тринидадын нөхцөл** (1990), Торонтогийн өргөтгөсөн нөхцөл(1991), 1999 оны 6-р сард Германы Кёльн хотноо болсон “Их наймын” дээд хэмжээний уулзалтаас нэн их өртэй ядуу орнуудын талаар гаргасан **Кёльний Өрийн Санаачлага** (Keln HIPC Debt Initiative) зэрэг баримт бичгийн заалтыг үндэслэн нааштайгаар шийдвэрлэх боломж нөхцөл байсан эсэх талаар хараат бус хөндлөнгийн шинжээчдийн олон улсын баг ажиллуулж, үнэлгээ хийлгэж гарсан үр дүнг Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцэн Монголын түүхэнд ямраар үлдэхийг нь нэг мөр болгон шийдвэрлэмээр санагддаг.

БНХАУ-ын дарга Ху Зинтао анх удаа гадаадад хийсэн айлчлалынхаа явцад 2003 эхний хагаст манай улсад айлчилж Монгол, Хятадын харилцааг түншийн харилцаа хэмээн тодорхойлов. Мөн НҮБ-ын ивээл ор “Ардчиллыг шинээр болон сэргээн хөгжүүлсэн улс орнуудын тавдугаар бага хурлыг” 9-р сард Монгол Улсад зохион байгуулав. Монголд хандивлагч орнуудын ээлжит уулзалт 11-р сард Токио хотноо болж 2004 онд Монгол Улсад 335 сая долларын зээл тусламж үзүүлэхээр болсон зэрэг онцлог үйл явдал 2003 онд болж өнгөрлөө. Монгол улсын сүүлийн 7 жилийн эдийн засгийн гол гол үзүүлэлтүүдийг дараах хүснэгтээс үзнэ үү.

Монгол Улсын эдийн засгийн гол үзүүлэлт (1997-2003)

	1997 он	1998 он	1999 он	2000 он	2001 он	2002 он	2003 он
ДНБ-ийн өсөлт /өмнөх оныхтой харьцуулсан %/	4.0	3.5	3.2	1.1	1.1	4.0	5.5
Уул уурхайн үйлдвэрлэл /өмнөх оныхтой харьцуулсан %/	4.4	3.2	1.3	2.4	11.8	3.8	2.0
Хэрэглээний үнийн өсөлт /өмнөх оны эцэстэй харьцуулсан %/	20.5	6.0	10.0	8.1	11.2	1.6	4.7
Дотоодын төмөр замын ачаа тээвэрлэлт /сая тн/км/	2554.2	2815.3	3491.7	4282.5	5287.9	6461.3	7253.3
Ажилгүйчүүдийн тоо /мянган хүн/	63.7	49.8	39.8	38.6	40.3	30.9	33.3
Доллартай харьцах төгрөгийн ханш /хугацааны эцсээр/	813.2	902.0	1072.4	1097.0	1102.0	1125.0	1168.0
Гадаад худалдааны баланс /сая ам.\$/	▲16.8	▲158.1	▲154.5	▲78.7	▲116.2	▲166.8	▲187.1
Экспорт /сая ам. \$/	451.5	345.2	454.2	535.8	521.5	524.0	600.2
Импорт /сая ам. \$/	468.3	503.3	512.8	614.5	637.7	690.8	787.3
Улсын санхүүгийн баланс /тэрбум төгрөг/	▲65.1	▲102.1	▲98.2	▲69.7	▲45.5	▲70.0	▲80.7
Малын хорогдол /сая толгой/	0.6	0.7	0.8	3.5	4.7	2.9	1.3

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн
Эмхтгэл /1997-2003 он/

Бүс нутгийн орнуудын хөгжийн хандлага, таамаглал

Дэлхий дахинаа ихээхэн нэр хүндтэй “The Economist” сэтгүүлийн газар 2004 онд дэлхийн хөгжлийн хандлага ямар байх талаар судалгаа хийж таамаглал дэвшүүлжээ. Бид “The Economist” сэтгүүлийн газраас эрхлэн гаргасан “The World in 2004” гэсэн тусгай товхимолд ЗХА-ийн орнуудын эдийн засгийн хөгжлийн талаар дэвшүүлсэн таамаглалыг танилцуулья.

Тэнд ерөнхийдөө өсөлт бага зэрэг буурах боловч эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтүүд боломжийн хэмжээнд байна гэсэн өөдрөг таамаглал дэвшүүлжээ. Гэхдээ таамаглал тэр бүр бодитой байдаггүй. Дээрхи таамаглал хэр үндэслэлтэй гарахыг бид та бүхэнд ирэх жил танилцуулах бодолтой байна. Одоо бид дэвшүүлсэн таамаглалыг орон тус бүр дээр авч үзье.

Япон Энэ онд Японы эдийн засаг өмнөх оноос бага зэрэг саарч ДНБ нь 1,6 хувийн өсөлттэй байх бөгөөд түүний нийт хэмжээ нь 4,366

тэрбум ам. доллар болох аж. Инфляц $-0,5$ хувьтай байна. Хүн ам нь 127,1 саяд хүрнэ. Хүн ам тутамд 34,350 ам. долларын ДНБ ногдох аж.

Хятад Энэ оны хувьд Хятадын ДНБ-ий өсөлт өнгөрсөн оноос буурч 8,2 хувийн өсөлттэй байх бөгөөд түүний нийт хэмжээ нь 1,463 тэрбум ам. доллар болох аж. Инфляц 0,9 хувьтай байна. Хүн ам нь 1,3 тэрбумд хүрнэ. Хүн ам тутамд 1,120 ам. долларын ДНБ ногдох аж.

Орос Энэ оны хувьд Оросын ДНБ-ий өсөлт өнгөрсөн оноос буурч 4,2 хувийн өсөлттэй байх бөгөөд түүний нийт хэмжээ нь 449 тэрбум ам. доллар болох аж. Инфляц 11,6 хувьтай байна. Хүн ам нь 144,4 саяд хүрнэ. Хүн ам тутамд 3,110 ам. долларын ДНБ ногдох аж.

Өмнөд Солонгос Энэ оны хувьд Өмнөд Солонгосын ДНБ-ий өсөлт өнгөрсөн оноос өсч 4,3 хувийн өсөлттэй байх бөгөөд түүний нийт хэмжээ нь 563 тэрбум ам. доллар болох аж. Инфляц 2,1 хувьтай байна. Хүн ам нь 48,4 саяд хүрнэ. Хүн ам тутамд 11,630 ам. долларын ДНБ ногдох аж.

Харин Өмнөд Солонгосын **Think-tank**(Оюуны төв) болох Солонгосын хөгжлийн институт /KDI/-ээс нийтэлсэн урьдчилсан төлөвөөс үзэхэд Өмнөд Солонгосын эдийн засгийн өсөлт энэ онд 5.5%-тай байх ажээ. Уг судалгаанд дотоодын эрэлт хэрэгцээ сул байгааг харгалзан эдийн засагт түлхэц болж өгөхүйц валют санхүүгийн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, санхүүгийн салбарт бүтцийн өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатайг цохон тэмдэглэсэн байна. Азийн хөгжлийн банкны таамаглалаар бол эдийн засаг 5.2%-иар өсөх аж. Дээрх 3 таамаглалын сүүлчийн 2 нь бараг ижил, эхнийх нь нэлээд зөрөөтэй байна.

Хойд Солонгос Энэ оны хувьд БНАСАУ-ын ДНБ өнгөрсөн оноос өсч 1,5 хувийн өсөлттэй байх аж. Тус улсын экспорт 2,1 тэрбум ам. доллар, импорт 2,3 тэрбум ам. долларт хүрэх гэнэ. Хүн ам нь 22,6 сая болж өсөх аж.

Монгол Дээр өгүүлсэн судалгаанд манай улсын талаар ямар нэгэн мэдээлэл алга. Азийн хөгжлийн банкнаас бүс нутгийн хөгжлийн чиг хандлага ямар байх талаар таамаглал дэвшүүлж түүнийгээ тусгай товхимол болгон нийтэлдэг. Энэ товхимолд дурьдсанаар дотоодын нийт бүтээгдэхүүн 2004 онд 5,8 хувь, 2005 онд 6,0 хувиар тус тус өсөх өөдрөг таамаглал дэвшүүлжээ. 2003 онд SARS-ын улмаас 21 хувиар саарсан аялал жуулчлалын салбар сэргэж үйлчилгээний салбарын

өсөлтөд тодорхой хувь болох юм байна. Гадаад худалдааны тэнцэлийн алдагдал ДНБ-ий 14 хувьтай тэнцэхээр байгаа гэнэ.

Бидний тооцоолж байгаагаар Алтанбулагийн Худалдааны чөлөөт бүс, Замын үүдийн Эдийн засгийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалт энэ ондоо багтаж эхэлбэл гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ огцом өсөх магадлалтай.

Дэлхийн хамгийн ядуу орны нэг болох манай улсын хувьд найдвар тавьж байгаа зүйл маань гадаадын хөрөнгө оруулалт. Хүсэхэд хясах гэгчээр гадаадын хөрөнгө оруулалтад боломжийн таатай эрх зүйн орчин бүрдүүлсэн хэдий ч өнөө хэр стратегийн чанартай хөрөнгө оруулагчид бараг алга /Оюу толгойн ордоос бусад/. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын энэ таатай нөхцлийг урд хөрш маань л харин дээд зэргээр ашиглаж, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн дүрмийн сангийн хөрөнгийн доод хэмжээ болох 10 мянган ам.долларыг 10 хятад тус бүр 1000 ам. доллар гаргах буюу 10 мянган ам.долларын үндсэн хөрөнгө нэрээр 10 хятад хэдэн халуун тогоо /тэр нь хүний эрүүл мэндэд онц хортой химийн хүнд элемент агуулсан байдаг гэнэ/ оруулж ирээд гуанз, цайны газархан, арьс шир, ноос ноолуур цуглуулах, төмөр хайлуулах, мод гаргах гэх мэтээс нэг их хэтрэхгүй, үндэсний үйлдвэрлэлийн өсөлтөд сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулж, тооны хувьд хэт их олон, чанарын хувьд дэндүү хангалтгүй Хятадын хөрөнгө оруулалттай компани байгуулдаг зуршил нэгэнт тогтлоо. Үүнийг цэгцлж хөрөнгө оруулалтын чиглэл, нөхцөл болзол, дүрэм журам болон түүний босгыг өндөрсгөхгүй бол хожим хойно харамсаад барахгүй үр дагавар учирч болзошгүй.

Үндэстэн дамнасан корпорацуудын зүгээс Монголыг сонирхож манай залуучуудыг ажлын байраар хангах асар их боломж байсаар. Тэднийг өөртөө татаж чадвал сүлжээнийх нь бүтээгдэхүүний өчүүхэн эрэг шураг гэх мэт жижигхээн зүйлийг л стандартынх нь дагуу тогтмол нийлүүлээд байх боломж бий. Түүнчлэн мэдээллийн технологийн чиглэлээр программ боловсруулах захиалга хөгжиж буй орнуудад сүүлийн үед их ирэх боллоо. Үүнийг олж авах талаар санаачлага гаргаж чадвал **Outsourcing** буюу гадаад нөөц зах зээлийг ашиглаж ажилтай болох зэрэг глобалчлалаас олгож буй өргөн боломж байгаа билээ. Мөн импортын зарим бараа бүтээгдэхүүнд дахин боловсруулалт хийж экспортлох чиглэлээр бараа бүтээгдэхүүнийг төвлөрүүлэх, хадгалах, ангилах, түгээх **Логистик** төвүүдийг бий болгож чадвал ажлын байр нэмэгдүүлж экспортыг өсгөх бас нэг боломж бий. Дараагийн нэг боломж

гэвэл маш эмзэг эдийн засагтай, нэн ядуу, буурай хөгжилтэй орны НҮБ-ын ангилалд хэдэн жилийн хугацаатайгаар багтан орж, энэ ангилалд орсон орнуудад үзүүлдэг нэн таатай боломж, хөнгөлөлтийг эдэлж, эдийн засгийн гадаад харилцааны хувьд Орос, Хятадын зүгээс тогтоож буй гааль, худалдааны тарифын болон тарифын бус хориг саад хязгаарлалтуудын өндөр босгыг давж гарах хэрэгтэй байна.

Дэлхийн худалдааны байгууллагын шугамаар манай улсад явуулсан “Олон улсын худалдааны бодлого” төслийн хүрээнд Хятад улс ДХБ-д элсээд хөрш орнууддаа үзүүлэхээр амласан худалдааны нэн таатай боломж, ОХУ энэ байгууллагад элсвэл манайд үзүүлэх хөнгөлөлт үр нөлөө ямар байх талаар хийсэн судалгаанаас үзэхэд манайд оногдох ашгийн хувьд тун маруухан байх аж. Энэ бүхэнд дүгнэлт хийж ДХБ-ын гишүүн орны хувьд бүс нутгийн чөлөөт худалдааны гэрээ хэлэлцээрийн боломжийн талаар судалгаа хийх, бусад олон талт хамтын ажиллагааны бүтцэд идэвхтэй оролцох хэрэгтэй байна.

Манай улс дэлхий дээр гадаадын тусламжаас хамгийн их хамааралтай улс. 1991 оноос хойш 3 тэрбум ам. долларын тусламж авсан. Гадаад өр нь ДНБ-ий 91 хувьтай тэнцэж байгаа, улсын төсвийн тэн хагасыг гадаадын хөрөнгө оруулалт хаадаг улс. Улс орноо хөгжүүлэх гэхээсээ илүү улсын төсвийн зарлагаа жил бүр өсгөн нэмэгдүүлдэг, захиргааны хүнд сурталт аппаратаа тасралтгүй нэмэгдүүлдэг гаж тогтолцоо үйлчилсээр байгаа нь хөгжлийг урагш биш хойш чангаах гол хүчин зүйл болж байна. Энэ гаж тогтолцоог зөв голдиролд нь оруулж Эстоны хөгжлийн загварыг шууд хуулах, е-засаглал хэрэгжүүлэх, тансаг хэрэглээний өндөр үнэтэй жийп хэрэглэхээс ухамсартай татгалзах, бусад үрэлгэн хэрэглээгээ эрс багасгаж хуримтлал бий болгох, төсвийн зардлаа одоогийнхоос даруй 50%-иар бууруулж чадсан нөхцөлд л хүний төлөө, хөгжлийн төлөө хөрөнгө оруулалт тэр дундаа гадаадын шууд хөрөнгө оруулалт эрс нэмэгдэж, үндэстэн дамнасан корпорациуд Монголыг сонирхож эхлэх магадлалтай. Үүн дээр нэмээд ард түмнээ эксел биш компьютер сонирхдог, анхны хуримтлал бий болгодог болгохсон. Монголын ард түмний заяа буян түшиж Америкийн Мянганы сорилын данснаас хувь хүртэх эрхтэй боллоо. Үүнийг эргүүлээд Америкт нь тушааж оронд нь 30 мянган охид хөвгүүдээ үнэ төлбөргүй сургаж авах эр зориг гаргахсан. Төр засаг ийм шийдвэр гаргаж чадвал улс орны хөгжлийн тулах цэг, зөв эхлэлийн нэгэн гарцаагүй тэр мөн болохсон билээ.

Одоо бид бүс нутгийн орнууд маань глобалчлалын шинэ эриний хөгжлийн үндсэн үзэл баримтлал, түүнийг залан чиглүүлэгч гэж албан ёсоор хүлээн зөвшөөрөгдөөд буй шинэ сонгодог либерализмын амин сүнс нь болсон эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлтүүд нь ямар байгааг авч үзье. Энэ үзүүлэлт нь бүс нутгийн орнууд аль хэр глобалчлагдаад байгааг тодорхой харуулдаг нэг ёсны барометр гэж хэлж болно. Дэлхийд нэрд гарсан судалгааны байгууллага болох АНУ-ын “Heritage Foundation” жил бүр дэлхийн улс орнуудын эдийн засгийн эрх чөлөөний индексийг судлан тогтоодог уламжлалтай. Уламжлал ёсоор 2003 оны индексийг “The Wall Street” сэтгүүлд нийтэлснийг бид өмнөх судалгаандаа оруулсан. Индексийн гол шалгуур үзүүлэлтээр тухайн орны худалдаа, санхүүгийн дарамт, эдийн засагт засгийн газрын оролцоо, мөнгөний бодлого, гадаадын шууд хөрөнгө оруулалт, банк, санхүүгийн бодлого, цалин хөлс, үнэ ханш, өмчийн эрх, төрийн зохицуулалт, далд зах зээл гэсэн арван үзүүлэлтийг гол шалгуур үзүүлэлт болгон авч үзсэн байна. Дээрхи үзүүлэлт 3,0-ээс доош байх юм бол тухайн орны эдийн засаг бүрэн нээлттэй, чөлөөт бус хаалттай бодлого баримтладаг оронд тооцдог юм байна. ЗХА-ийн зургаан орны хувьд Япон 2,50 гэсэн ерөнхий оноогоор 35-р байранд, Өмнөд Солонгос 2,70 оноогоор 52-т, Монгол 3,00 оноогоор 72-т, Хятад 3,55 оноогоор 127-д, Орос 3,70 оноогоор 135-д, БНАСАУ 5,00 оноогоор 156-д буюу доороосоо нэгд явна. Дээрхи үзүүлэлтээс харахад Япон, Өмнөд Солонгосоос бусад орнуудад эдийн засгийн эрх чөлөө ямар нэгэн хэмжээгээр хязгаарлагдмал гэсэн судалгаа гарчээ. Өөрөөр хэлбэл глобалчлалын урсгалд нэгдэн нийлэх тал дээр улс орон бэлэн бус байна гэсэн үг. Иймд дээрхи орнууд эдийн засгаа улам бүр либералчилж нээлттэй болгох нь улс орны цаашдын хөгжлийн эрх ашигт нийцэх биз ээ. ЗХА-ийн орнуудын эдийн засгийн эрх чөлөөний индексийг дараах хүснэгтээс үзнэ үү.

ЗХА-ийн орнуудын эдийн засгийн эрх чөлөөний индекс

Зарчлал	Улс	Ер. Оноо	Худалдаа	Санхүүгийн дарамт	ЗГ-ын оролцоо	Мөнгөний бодлого	ПШО	Банк санхүү	Цалин хөлс үнэ ханш	Өмчийн эрх	Зохицуулалт	Далд зах зээл
1.	Япон	2,50	2,0	4,0	3,0	1,0	3,0	3,0	2,0	2,0	3,0	2,0
2.	БНСУ	2,70	3,0	3,0	4,0	2,0	2,0	3,0	2,0	2,0	3,0	3,0
3.	Монгол	3,00	2,0	4,5	2,5	3,0	3,0	3,0	2,0	3,0	4,0	3,0
4.	Хятад	3,55	5,0	3,0	4,0	1,0	4,0	4,0	3,0	4,0	4,0	3,5
5.	Орос	3,70	4,0	3,5	2,5	5,0	3,0	4,0	3,0	4,0	4,0	4,0
6.	БНАСАУ	5,0	5,0	5,0	5,0	5,0	5,0	5,0	5,0	5,0	5,0	5,0

Эх сурвалж: Хөгжлийн эдийн засгийн асуудлууд, 2003.№8

Эдийн засгийн глобалчлалын шалгуур үзүүлэлт болох Эдийн засгийн эрх чөлөөний индекс ЗХА-ийн орнуудын хувьд энэ онд Японоос бусад нь өмнөх оныхоос бага зэрэг урагш ахих төлөвтөй байгаа аж. Тухайлбал Япон 38, Өмнөд Солонгос 47, Монгол 65, Орос 114, Хятад 126, Хойд Солонгос 152-р байранд байхаар эрэмбэлэгджээ.

ЗХА-ийн орнуудын хувьд Орос улс энэ бүсийнхээ хөгжлийг түргэтгэх чиглэлээр тодорхой зорилт тавьж БАМ-ын төмөр замаа бүрэн хэмжээгээр ашиглалтад орууллаа. Хятадын зүүн хойт 3 мужийг төрийн бодлого зохицуулалтаар бүс нутгийн интеграцыг утгуулан эрчимтэй хөгжүүлснээр түүний эдийн засгийн өсөлт хөгжил нь 2 оронтой тоогоор илэрхийлэгдэх болов. Хойд, Өмнөд Солонгос ч зүгээр суусангүй энэ чиглэлд багагүй зүйл хийж амжуулжээ. Хятад Япон, Япон Өмнөд Солонгос чөлөөт худалдааны гэрээ хэлэлцээр байгуулах талаар шаргуу ажиллаж ирлээ. Тэгвэл манай зүүн хойт бүс нутагт бид юу хийж амжуулсан билээ гээд бодоход хэлэх юмаар маруухан энэ бүс хөгжлөөрөө бусад нутгуудаас ялгарах юмгүй л явна. Дэд бүтэц зэгсэн хөгжсөн, хүн ам харьцангуй нягт сууршилттай энэ нутагт Өмнөд Солонгос, Японы шинэ технологийн парк байгуулан хөгжүүлэх хамгийн ирээдүйтэй бүс нутаг гэж бид олонтаа тэмдэглэж ирсэн билээ.

Ашигласан эх сурвалж:

1. ERINA Report., 2003. December, Vol. 55, 2004 February, Vol. 56, May, Vol. 57
2. The Economist. World in 2004
3. Asian Development Bank Report. 2003
4. World Bank Report 2003
5. Asian Survey 2004, N°1
6. Beijing Review Vol. 46, Dec. 18, 2003
7. See-<http://www.khan.co.kr/> December 16, 2003
8. See-<http://www.utro.ru/> articles Dec.
9. See-<http://www.japantimes.co.jp/> Dec. 2003
10. Хөгжлийн эдийн засаг сэтгүүл 2004 N°1
11. Business Times 2004 1-5 сар
12. Өдрийн сонин .2004. 05.03
13. Japan Almanac 2002 Asahi shinbun sha 2002
14. Globalization no koozai to ajia no shourai /Глобалчлалын үр дагавар ба Азийн ирээдүй/ JETRO 2000

15. Nihon keizai nyumon 2003 /Японы эдийн засаг эхлэн суралцах 2003/ Nihon keizai shinbun sha 2003
16. Martin Banze. Impact of Russian WTO Membership on Mongolia /Shortterm Study in the GTZ Project “Mongolian German Cooperation in the Field of International Trade Policy WTO”/
17. Martin Banze. Impact of Chinese WTO Membership on Mongolia /Shortterm Study in the GTZ Project “Mongolian German Cooperation in the Field of International Trade Policy WTO”/
18. “Олон улс судлал” 2003. №4;
19. “Олон улс судлал” 2004. №1
20. CIA World Factbook, 2002, World Bank
21. Монгол Улсын Статистикийн эмхтгэл, УБ, 2003